



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар A/152

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “д”, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит V хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан Мөрөн сумын 9 дүгээр хорооны асфальтан хучилттай авто замын уулзварыг өргөтгөх 18,923,435 (Арван найман сая есөн зуун хорин гурван мянга дөрвөн зуун гучин таван) төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, “Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах 310,000,000 (Гурван зуун арван сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, Мөрөн сумын шаардлагатай газруудад гэрлэн дохио суурилуулах 60,000,000 (Жаран сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар, Улаан-Уул сумын Тоомын давааны 1,687 км хайрган хучилттай авто зам, 5 ш модон хоолойг засварлах 238,247,010 (Хоёр зуун гучин найман сая хоёр зуун дөчин долоон мянга арван) төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дөрөвдүгээр, Рэнчинлхүмбэ сумын Сантын давааны авто замыг засварлах 139,529,805 (Нэг зуун гучин есөн сая таван зуун хорин есөн мянга найман зуун таван) төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, зураг, төсөл, техник эдийн засгийн үндэслэл, өртгийн тооцооллыг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД



Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын  
06-ны өдрийн А/152 дугаар захирамжийн  
01 дүгээр хавсралт

МӨРӨН СУМЫН 9 ДҮГЭЭР ХОРООНД АСФАЛЬТАН ХУЧИЛТТАЙ  
АВТО ЗАМЫН УУЛЗВАРЫГ ӨРГӨТГӨХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-18,923,435 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
дарга


Гишүүд: Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

О.Алтантэриа-Аймгийн Хот тохижуулах үйлчилгээний төвийн бичиг хэргийн  
ажилтан

Н.Шинэбаяр-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын  
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ц.Дэлгэр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын  
06 -ны өдрийн А/152 дугаар захирамжийн  
02 дугаар хавсралт



**МӨРӨН СУМЫН ШААРДЛАГАТАЙ ЦЭГҮҮДЭД ХЯНАЛТЫН  
КАМЕР СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-310,000,000 төгрөг)**

Үнэлгээний хорооны дарга: Г.Гандэлгэр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн  
Ч.Сэрээнэн-"Тэмээн" ХХК-ийн захирал  
О.Эрдэнэбаатар-Мөрөн сумын иргэн

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын  
06-ны өдрийн А/152 дугаар захирамжийн  
03 дугаар хавсралт



**МӨРӨН СУМЫН ШААРДЛАГАТАЙ ЦЭГҮҮДЭД ГЭРЛЭН  
ДОХИО СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**  
(Төсөвт өртөг-60,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Г.Гандэлгэр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ч.Сэрээнэн-"Тэмээн" ХХК-ийн захирал

Ж.Улаанбаатар-Мөрөн сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Ц.Эрдэнэбаатар-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн



Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын  
06-ны өдрийн А/152 дугаар захирамжийн  
04 дүгээр хавсралт



УЛААН-УУЛ СУМЫН ТООМЫН ДАВААНЫ 1,687 КМ ХАЙРГАН  
ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 5 Ш МОДОН ХООЛОЙ ЗАСВАРЛАХ  
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ  
БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-238,247,010 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Э.Аззаяа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн  
Ч.Эрдэнэчимэг-"Ойн цэцэрлэг" ХХК-ийн захирал  
О.Эрдэнэбаатар-Мөрөн сумын иргэн

Нарийн бичгийн дарга: З.Гал-Эрдэнэ-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын  
06-ны өдрийн А/152 дугаар захирамжийн  
05 дугаар хавсралт



РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН САНТЫН ДАВААНЫ  
АВТО ЗАМЫГ ЗАСВАРЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-139,529,805 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Б.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ш.Далайбаяр-Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын орлогч

П.Ням-Эрдэнэ-"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн ашиглалтын инженер

Нарийн бичгийн дарга: З.Батбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн